



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ОРА-2021/3/СТА-ОНӨААН**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа

Утас: 70357955 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	0
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	0
4 .....	1
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ.....	1
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан .....	2
3.Аудитын тайлан.....	3
3.1. Ерөнхий зүйл.....	3
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	3
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	4
3.4. Материаллаг байдал .....	5
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	5
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	6
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа .....	8
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	8
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.10. Аудитын илрүүлэлт.....	9
Залруулсан алдаа.....	9
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	10
4. Менежментийн захидал .....	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	11

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.03.15 № 86

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРДЭНЭТ-УС ДТС ОНӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Д.БҮҮВЭЙБААТАР ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	713,581,448.54	388,700,010.87
1.1.2	Дансны авлага	8,590,118,592.14	10,149,243,462.49
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	34,260,866.71	15,789,656.72
1.1.4	Бусад авлага	5,095,102.13	4,328,620.06
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	1,982,822,437.23	1,976,276,222.73
1.1.6	Бараа материал	586,183,933.52	598,487,593.80
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	4,500,888,294.83	5,402,279,623.69
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>11,912,062,381.27</b>	<b>13,132,825,566.67</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	35,396,867,874.75	36,345,699,742.35
1.2.2	Биет бус хөрөнгө	178,340,330.62	157,316,108.62
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	4,500,888,294.83	5,402,279,623.69
1.2.9			
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>42,541,491,500.20</b>	<b>44,370,690,474.66</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>54,453,553,881.47</b>	<b>57,503,516,041.33</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	89,99,805,214.38	9,868,572,749.04
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	5,389,949.19	4,305,476.61
2.1.1.4	НДШ – ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	637,881,339.17	487,186,737.69
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	40,312,989.85	36,744,455.62
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>9,683,389,492.59</b>	<b>10,396,809,418.96</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

2.1.2.3	Хойшлогдсон орлого	4,500,888,294.83	5,402,279,623.69
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	4,500,888,294.83	5,402,279,623.69
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	14,184,277,787.42	15,799,089,042.65
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	5,231,568,753.18	5,231,568,753.18
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,589,755,958.06	2,588,875,182.68
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	37,282,875,393.16	39,250,136,404.16
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(4,834,924,010.35)	(5,366,153,341.34)
2.3.10	Тайлант үеийн ашиг		(532,110,106.37)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	40,269,276,094.05	41,704,426,998.68
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	54,453,553,881.47	57,503,516,041.33

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	16,420,696,259.14	17,995,893,360.0
2	Борлуулалтын өртөг	10,325,039,897.82	11,082,566,644.60
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	6,095,656,361.32	6,913,326,715.40
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	4,220,152.71	1,742,084.03
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	123,733,100.0	166,329,800.0
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	7,109,935,463.02	7,772,099,594.28
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(2,019,227.62)	(24,625,713.66)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)	309,132,200.57	186,326,551.34
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	(583,433,028.75)	(530,742,241.20)
19	Орлогын татварын зардал	2,489,785.70	1,367,865.17
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	(585,922,814.45)	(532,110,106.37)
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	(585,922,814.45)	(532,110,106.37)
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>		
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	5,231,568,753.18		2,529,646,905.83	27,699,203,678.48	(4,188,892,143.67)	31,271,527,193.82
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
<b>Залруулсан үлдэгдэл</b>			60,109,052.23		(60,109,052.23)	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(585,922,814.45)	(585,922,814.45)
Өмчид гарсан өөрчлөлт				9,583,671,714.68		
Зарласан ногдол ашиг						
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	5,231,568,753.18		2,589,755,958.06	37,282,875,393.16	(4,834,924,010.35)	40,269,276,094.05
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(38,732,798.68)	(38,732,798.68)
<b>Залруулсан үлдэгдэл</b>			(880,775.38)		880,775.38	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(532,110,106.37)	(532,110,106.37)
Зарласан ногдол ашиг						
Өмчид гарсан өөрчлөлт				1,967,261,011.00		1,967,261,011.00
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	5,231,568,753.18		2,588,875,182.68	39,250,136,404.16	(5,366,153,341.34)	41,704,426,998.68

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				/төгрөгөөр/
Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31	
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	18,504,831,027.92	20,234,315,012.74	
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	16,643,424,045.96	18,676,772,869.92	
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого			
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө			
	Буцаан авсан албан татвар			
	Татаас, санхүүжилтийн орлого	1,216,865,649.00	1,094,429,388.00	
	Бусад мөнгөн орлого	664,541,332.96	463,112,754.82	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	18,004,517,023.25	20,251,544,7875.41	
	Ажиллагчдад төлсөн	2,818,696,573.88	3,314,131,885.22	
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	864,000,000.00	999,000,000.00	
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,016,791,899.00	1,212,091,550.90	
	Ашиглалтын зардалд төлсөн	583,330,319.44	700,174,540.82	
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	175,534,200.00	205,430,900.00	
	Хүүний төлбөрт төлсөн			
	Татварын байгууллагад төлсөн	816,270,799.88	760,692,009.85	
	Даатгалын төлбөрт төлсөн			
	Бусад мөнгөн зарлага	11,729,893,231.05	13,060,023,988.62	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	500,314,004.67	(17,229,862.67)	
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
2.1	Мөнгөн орлогын дүн (+)			
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого			
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого			
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого			
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого			
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт			
	Хүлээн авсан хүүний орлого			
	Хүлээн авсан ногдол ашиг			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	267,865,040.0	307,651,576.0	
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	267,865,040.0	307,651,576.0	
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн			
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн			
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн			
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	267,865,040.0	307,651,576.0	
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
3.1	Мөнгөн орлогын дүн (+)			
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан			
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан			
	Төрөл бүрийн хандив			

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	232,448,964.67)	(324,881,438.67)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	481,132,484.87	713,581,449.54
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	713,581,449.54	388,700,0108.7

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д.д	Үндсэн үзүүлэлтүүд	Хэм жиг нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 он		/төгрөг/	
				төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Орон тоо	мян.төг	323	323	322		
2	Үндсэн ба нэмэгдэл цалин	мян.төг	3,435,565.1	3,925,223.8	3,852,324.3	72,899.5	98.1
3	Ажил олгогчийн төлөх НДШ	мян.төг	463,770.0	529,905.2	524,355.5	5,549.7	98.9
4	Цахилгаан	мян.төг	637,838.0	655,435.8	737,881.6	(82,445.8)	112.5
5	Дулаан -өөрийн хэрэглээ	мян.төг	16,894.9	19,764.3	20,878.3	(1,114.0)	105.6
6	Ус -өөрийн хэрэглээ	мян.төг	32,451.1	24,114.9	29,249.2	(5,134.3)	121.2
7	Урсгал засвар, сэлбэг	мян.төг	263,438.6	345,237.3	269,698.2	75,539.1	78.1
8	Түлш шатахуун	мян.төг	134,041.2	162,393.5	131,306.4	31,087.1	80.8
9	Албан томилолт	мян.төг	12,955.4	15,468.0	2,778.3	12,689.7	17.9
10	Бичиг хэрэг	мян.төг	19,035.4	26,132.3	17,884.0	8,248.3	68.4
11	Холбоо	мян.төг	25,313.5	34,548.8	25,931.2	8,617.6	75.0
12	Хөдөлмөр хамгаалал	мян.төг	147,112.3	152,684.4	135,905.4	16,779.0	89.0
13	Үндсэн хөрөнгийн элэгдэл	мян.төг	1,508,866.8	1,637,155.4	1,663,114.3	(25,958.9)	101.5
14	Зар сурталчилгаа	мян.төг	1,880.0	6,000.0	2,059.1	3,940.9	34.3
15	Нийгэм халамжийн зардал	мян.төг	102,788.0	146,101.9	140,523.4	5,578.5	96.1
16	ТЗЭ-ийн зохицуулалтын хөлс	мян.төг	44,081.1	31,438.1	34,165.0	(2,726.9)	108.6
17	Татвар даатгалын зардал	мян.төг	28,376.1	46,588.3	30,583.6	16,004.7	65.6
18	Гадны үйлчилгээний хөлс	мян.төг	26,536.2	59,856.6	31,741.9	(28,114.7)	53.0
19	Бусад үндсэн үйл ажиллагаа	мян.төг	208,992.1	94,469.3	121,720.0	(27,250.7)	128.8
20	Худалдан авсан эрчим хүчний өртөг	мян.төг	10,325,039.9	10,886,978.6	11,082,566.6	(195,588.0)	101.7
21	<b>Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн</b>	мян.төг	<b>17,434,975.4</b>	<b>18,799,496.6</b>	<b>18,854,666.3</b>	<b>55,169.7</b>	<b>100.3</b>
22	Борлуулалтын орлого	мян.төг	16,193,423.6	17,489,988.3	17,995,893.4	505,905.1	102.8
23	Бусад орлого	мян.төг	351,005.8	392,727.3	166,329.8	226,397.5	42.3
24	<b>Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн</b>	мян.төг	<b>16,544,429.4</b>	<b>17,882,715.6</b>	<b>18,162,223.2</b>	<b>(279,507.6)</b>	<b>101.5</b>
25	<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг алдагдал</b>	мян.төг	<b>(890,546.0)</b>	<b>(916,781.0)</b>	<b>(692,443.1)</b>	<b>(15.8)</b>	<b>101.8</b>
26	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	16,024.3	52,500.0	47,748.7	48751.3	90.9
27	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	320,647.5	315,000.0	208,081.7	106,918.3	66.0
28	<b>Өөрийн үйл ажиллагааны нийт ашиг алдагдал</b>	мян.төг	<b>(585,922.8)</b>	<b>(654,281)</b>	<b>(532,110.1)</b>	<b>(122,170.9)</b>	<b>81.3</b>
29	<b>Нийт орлого</b>	мян.төг		18,197,715.6	18,370,304.8	(172,589.2)	100.9
30	<b>Нийт зардал</b>	мян.төг		18,851,996.6	18,902,415.0	(50,418.4)	100.2

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Бүүвэйбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналтыг сайжруулах, найдваргүй авлага өр төлбөрийг барагдуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 09-өөс 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Гантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 123 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ орон нутгийн өмчит хувьцаат компани статустай байна.

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эрчим хүч, ус хангамжийн цогц бүтэцтэй, орчин үеийн технологийг нэвтрүүлсэн салбарын тэргүүний байгууллага болох” гэж тодорхойлсон байна.

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн ам, ААНБ-д стандартын шаардлага хангасан цэвэр усыг тасралтгүй түгээх
- Бохир усыг стандарт шаардлагын дагуу зайлуулах
- Хэрэглээний цэвэр усны алдагдлыг бууруулах, цэвэр усанд лабораторийн шинжилгээ хийх
- Хэрэглэгчдэд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах
- Орон сууцны барилга, байгууламжийн цэвэр бохир ус, цахилгаан, дулааны шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг гэрээний дагуу хийх
- Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ
- Лифт, эскалатор, зорчигчийн ган татлагат болон чирэх замын угсралтын ажил, засвар техникийн үйлчилгээ
- Хэргэлэгчдэд цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах
- Уст цэг, ус түгээх байрны ашиглалт, засвар үйлчилгээ
- Нийтийн эзэмшлийн барилга байгууламж, шугам сүлжээ, техник тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ, технологийн шинэчлэлт хийх түүнийш зориулалтын дагуу ашиглах
- Жаргалант, Дэнж багийн хэсгийн усан хангамжийн барилга, цэвэрлэх байгууламж, технологийн тоног төхөөрөмж шугам сүлжээний ашиглалт засвар үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрчим хүчний сайдын 2020 оны 267 дугаар тушаалын хавсралт “Цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах түр журам”
- Эрчим хүчний сайдын 2020 оны 269 дүгээр тушаалын хавсралт “Цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам”
- Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 242 дугаар тушаалын 1-р хавсралт “Цэвэр бохир усны хэрэглээг зохицуулах түр журам”
- Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 242 дугаар тушаалын 2-р хавсралт “Төрөөс хариуцах цэвэр бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам”
- Гүйцэтгэх захирлын 2020.01.15-ны өдрийн А/03 тоот тушаал “Эрдэнэт ус ДТС ОНӨХК-ийн цахилгаан, дулаан, усны тоолуур суурилуулах, солих, засварлах үед мөрдөх журам” /хавсралт 1-2/
- Гүйцэтгэх захирлын 2020.07.06-ны өдрийн А/46 дугаар тушаал “Айл өрх, ААНБ-ын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, бусад үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах журам” /хавсралт 1-5/

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Орон нутгийн өмчийн газраас Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас түүвэрлэн хяналт шалгалт хийж дараах зөвлөмжүүдийг өгсөн байна. Үүнд.

1. Тендерт оролцогч болон шалгараагүй оролцогч нарт мэдэгдлийг нэгэн зэрэг хүргүүлж, бүртгэл хөтөлж байх
2. Тендерийн хянан үзэх маягт-6 дээр гишүүдээр саналыг бичүүлж гарын үсэг зуруулж байх
3. Харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа цахимаар зарлах, урилга хүргүүлэх шаардлагагүй
4. Шалгарсан компанид гэрээ байгуулах эрх олгохдоо гэрээний үнийн дүн, нийлүүлэх хугацааг тавьж өгөх

Дотоод аудит, хяналт шалтгалтаар усны алдагдал бууруулах чиглэлээр техникийн нөхцөлгүй хангагч байгууллагын зөвшөөрөлгүй шугам сүлжээнд дур мэдэн холболт хийсэн хэрэглэгчийг илрүүлэн 33.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн. Говил багийн инженерийн шугам сүлжээ, ААНБ-д үзлэг шалгалт хийж зөрчилтэй ААНБ-ын шугам сүлжээг хэвийн болгон нөхөн төлбөр 3.5 сая төгрөгийг төлүүлсэн байна.

2020 оны ХАБЭА-н зөвлөлөөс хийх ажлын төлөвлөгөөг 2021 он хүртлэх техникийн бодлоготой уялдуулан 2 зүйлтэй боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Ажлын байрны багтаамж хүрэлцээ муу зарим ажлын байр стандарт шаардлага хангахгүй байгаа тул 2020 оны аймгийн төсөвт 900.0 сая төгрөг, 2021 оны аймгийн төсөвт 1.8 тэрбум төгрөгийн үлдэгдэл хөрөнгийг батлуулж барилгын ажлыг эхлүүлсэн байна.

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд сайн гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 3,422.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 34.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагатай гэж үзлээ. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант оны санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлт орлогын 7,265.9 сая төгрөгөөс 2 хувиар тооцож 145.3 сая төгрөгөөр тогтоолоо.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,050.0 сая төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	713.5	388.7	-324.8
Авлага	10,612.2	12,145.6	1,533.4
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	586.1	598.4	12.3
Үндсэн хөрөнгө	42,541.5	44,370.6	1,829.1
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>54,453.5</b>	<b>57,503.5</b>	<b>3,050.0</b>
Өр төлбөр	14,184.2	15,799.0	1,614.8
Эздийн өмч	40,269.2	41,704.4	1,435.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>54,453.5</b>	<b>57,503.5</b>	<b>3,050.0</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 388.7 сая төгрөг болж өмнөх оноос 324.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 20,330.3 сая төгрөгийн орлого орж 20,655.2 сая төгрөгийн зарлага гарснаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 12,145.6 сая төгрөг болж 1,533.4 сая төгрөгөөр өссөн нь дансны авлага өссөнөөс шалтгаалжээ. Өмнөх оноос айл өрх, аж ахуйн нэгж байгууллагаас 339.9 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ХХК /объём/-ийн 1,143.2 сая төгрөг, диспетчирийн үндэсний төвд урьдчилж төлсөн эрчим хүчний үнэ 160.0 сая төгрөгөөр өссөн, татвар, НДШ-ийн авлага 34.2 сая төгрөгөөс 15.7 сая төгрөг болж 18.4 сая төгрөгөөр, бусад авлага 5.0 саяас 4.3 сая төгрөг болж 0.7 сая төгрөгөөр тус бүр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэлд Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн объёмын зөрүү 2015 оноос үүссэн орлого болоогүй усны 8,986.8 сая төгрөгийн авлага ихэнх хувийг эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 598.4 сая төгрөг болж 12.3 сая төгрөгөөр өссөн нь шатахуун ба шингэн түлш тосолгооны материалын үлдэгдэл 30.6 сая төгрөгөөр өссөнөөс

шалтгаалжээ. Энэ нь ковид-19 тэй холбоотой шатахууны үнэ өснө гэж тооцон их хэмжээний шатахууныг нөөцөлж авсан байна.

Тайлант онд эхний үлдэгдэл 586.1 сая төгрөгийн бараа материал дээр өөрийн хөрөнгөөр 1,217.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 1,205.3 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 598.4 сая төгрөгийн бараа материал үлдсэн байна. Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 44,370.6 сая төгрөг болж 1,829.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн хөрөнгө 4,330.7 сая төгрөгөөр нэмэгдэж, хуримтлагдсан элэгдэл 2,476.9 сая төгрөгийн элэгдлийн зардлыг хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөөр худалдан авсан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар шилжиж ирсэн хөрөнгөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3,658.4 сая төгрөгийн хөрөнгө, балансаас балансад 24.0 сая төгрөгийн хөрөнгө шилжиж ирсэн, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 648.2 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 10,396.8 сая төгрөг болж 713.5 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн нэгж байгууллагын урьдчилж тооцсон өглөг, гэрээт албан газарт өгөх өглөг, худалдан авалтын өглөг зэргээс шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөрт гудамж, байр, замын гэрэлтүүлгийн хөрөнгийг өөрийн үндсэн үйл ажиллагаанд ашигладаггүй тул хойшлогдсон орлогоор бүртгэж тайлант хугацаанд хуримтлагдсан элэгдлээр хасагддаг ч жил бүр орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн гэрэлтүүлэг нэмэгдэж нийт өр төлбөрийг 5,402.2 сая төгрөгөөр өсгөж байна.

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл 15,799.0 сая төгрөг болж 1,614.8 сая төгрөгөөр өссөн нь гудамж замын гэрэлтүүлгийн хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн хөрөнгөөс шалтгаалжээ.

Гэрээт албан газарт өгөх өр 127.7 сая төгрөг, орлого болоогүй усны өр 8,723.3 сая төгрөг, худалдан авалтын 233.3 сая төгрөг, урьдчилж тооцсон 1,234.7 сая төгрөг, ажилчдад өгөх 36.7 сая төгрөг, ухаалаг худгийн карт 16.5 сая төгрөг, цэвэр усны тооцооны картын тооцоо 20.0 сая төгрөг, татварын өглөг 4.3 сая төгрөг нийт 10,396.8 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 41,704.4 сая төгрөг болж 1435.2 сая төгрөгөөр өссөн нь эздийн өмчийн бусад хэсэгт хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 2,589.7 сая төгрөгт тайлант онд дахин үнэлгээний үлдэгдэлтэй хөрөнгө акталсан тул 0.88 сая төгрөг хасагдаж 2588.8 сая төгрөг болж буурсан байна.

Эздийн өмчийн бусад хэсгийн үлдэгдэл 39,250.1 сая төгрөг болж 1,967.2 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр өссөн байна.

Өмнөх үеийн хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэл 4,834.9 сая төгрөг байснаас тайлант оны алдагдал 532.1 сая төгрөг, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний залруулгатай холбоотой 0.88 мянган төгрөгийг өмнөх үеийн үр дүнд хаах бичилт хийснээр хуримтлагдсан ашиг 5366.1 мянган төгрөг болж өссөн байна.

### **3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн дүрмийн 3.2-т заасны дагуу компани нь үйл ажиллагааны зорилго, чиглэл, эдийн засгийн үр ашгийг тодорхойлсон урт болон ойрын хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан түүнийг мөрдөж биелэлтийг ханган ажиллах үүрэгтэй.

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 25-ны 39 дүгээр тогтоолоор Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны бизнес төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 18,197,715.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 18,851,996.6 мянган төгрөгөөр, ашиг, алдагдлыг 654,281.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Оны эхэнд өөрийн хөрөнгөөр хийх 2020 оны үндсэн хөрөнгө, их засвар, ТЗБАХ-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг дулаан түгээх, цахилгаан түгээх, усан хангамж, ӨЭҮУХангамж, ариутгах татуургын 5 албанд нийт 981,710.7 мянган төгрөгийг баталсан байна. Гэвч жилийн дундуур эрчим хүчний зохицуулах хороонд хүсэлт явуулж, дулааны албаны их засварт 273,000.0 мянган төгрөгийг нэмсэн байна.

Гүйцэтгэлээр борлуулалтын орлого 17,995,893.4 мянган төгрөг, бусад орлого 166,329.8 мянган төгрөг, үйл ажиллагааны бус орлого 208,081.7 мянган төгрөг нийт 18,370,304.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 18,902,415.0 мянган төгрөгийн зардал гарган, 532,110.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Алдагдлын төлөвлөгөөг 654,281.0 мянган төгрөгөөр баталснаас 122,170.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөв-лөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Нийт орлого</b>	Мян.төг	<b>16,865,076.9</b>	<b>18,197,715.6</b>	<b>18,370,304.9</b>	<b>172,589.3</b>	<b>100.9</b>
	Цэвэр борлуулалт	Мян.төг	16,193,423.6	17,489,988.3	17,995,893.4	505,905.1	102.8
	Бусад орлого	Мян.төг	351,005.8	392,727.3	166,329.8	226,397.5	42.3
	Үйл ажиллагааны бус орлого	Мян.төг	320,647.5	315,000.0	208,081.7	106,918.3	66.0
<b>2</b>	<b>Нийт зардал</b>	Мян.төг	<b>17,450,999.7</b>	<b>18,851,996.6</b>	<b>18,902,415.0</b>	<b>(50,418.4)</b>	<b>100.2</b>
	Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	Мян.төг	10,325,039.8	10,886,978.6	11,082,566.6	(195,588.0)	101.7
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	Мян.төг	7,109,935.4	7,912,518.0	7,772,099.6	140,418.4	98.2
	Үйл ажиллагааны бус зардал	Мян.төг	16,024.3	52,500.0	47,748.7	48,751.3	90.9
	в) Хөрөнгө оруулалт их засвар	Мян.төг	644,474.0	1,191,762.3	953,427.9	238,334.4	81.6
<b>4</b>	<b>Өөрийн үйл ажиллагааны нийт ашиг алдагдал</b>	Мян.төг	<b>(585,922.8)</b>	<b>(654,281)</b>	<b>(532,110.1)</b>	<b>(122,170.9)</b>	<b>81.3</b>

Нийт орлогын гүйцэтгэл 18,370,304.8 мянган төгрөг болж төлөвлөснөөс 172,589.2 мянган төгрөг буюу 0.9 хувиар давж биелсэн нь шинэ объект нэмэгдэж, хэрэглэгчийн тоо өссөн мөн бусад гэрээт ажлын алданг болон банкны эхний 5 сарын хүүгийн орлого нэмж орсноос нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 18,902,415.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 50,418.4 мянган төгрөг буюу 0.2 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь өөрийн хэрэглээний цахилгаан, дулаан, ус, үндсэн хөрөнгийн элэгдэл, бусад үндсэн үйл ажиллагааны зардлууд хэтрэлттэй гарсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Цахилгаан, дулаан, ус хангамж, өөрийн эх үүсвэрийн усны хангамжийн 4 албанд их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардалд 1,191.7 мянган төгрөг баталснаас гүйцэтгэлээр 953.4 төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 532,110.1 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 122,170.9 мянган төгрөгөөр дутуу байгаа нь үйл ажиллагааны орлого 0.9 хувиар давж биелсэн, зардал 0.2 хувиар нэмэгдсэнээс тус тус шалтгаалж байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Алдагдалтай ажилладаг тул ногдол ашиг хуваарилдаггүй.

### 3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу аймгийн ИТХ-ын тэргүүлэгч 4, ИТХ-ын төлөөлөгч 1, агентлагийн дарга 3, барилга хот байгуулалтын яамны бодлого төлөвлөлтийн газрын дарга 1, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 1 удаа зохион байгуулж 3 асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. 2019 оны санхүү болон үйл ажиллагааны тайланд үнэлэлт, дүгнэлт өгөх
2. 2020 оны бизнес төлөвлөгөөг батлах
3. 2020 оны их болон урсгал засварын бараа материал худалдан авах төлөвлөгөөг батлах 3 асуудлыг хэлэлцэж, 5 тогтоол гаргасан байна.

2020 оны 6 дугаар сард худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, бүтэц орон тоонд гүйцэтгэх захирлын зөвлөх албан тушаалыг нэмж батлах тухай 2 тогтоол, 7 дугаар сард гүйцэтгэх захирлыг шагнаж урамшуулах тухай, гүйцэтгэх захирлыг ажлаас чөлөөлөх тухай 2 тогтоол гаргаж тайлант онд нийт 9 тогтоол гаргасан байна.

2020 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 5,400.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 8,188.1 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: 2019 оны ТУЗ-ийн цалинд 4.0 сая төгрөг, 2020 оны цалинд 2.0 сая төгрөг нийт цалинд 6.0 сая төгрөг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих өвөлжилтийн бэлтгэл хангах болон хурлын зардалд 2.0 сая төгрөгийн шатахууны зардлыг тус тус санхүүжүүлсэн байна.

### 3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 170 мэдээллээс 57 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй 15 мэдээллийг хугацаа хоцроож, 106 мэдээллийг байршуулаагүй байна.

### 3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт	Биелэлт	Гүйцэтгэлийн хувь
----------	---------------------	---------	-------------------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	88.2	1	88.2	100%
Албан шаардлага	3	2,471.2	3	2,471.2	100%
Зөвлөмж	3		2		80%
Нийт дүн	7	2,559.4	6	2,559.4	

### 3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7,400,700.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,012,762.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,246,757.2 төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 3,141,180.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлан, авлага, өр төлбөрийн тодруулга тайлангийн үлдэгдэл 2,012.7 сая төгрөгөөр өөрчлөгдсөнийг аудитын явцад залруулсан.

#### Төлбөрийн акт, албан шаардлага

1. 2019 оны санхүүгийн аудитаар авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зөвлөмж хүргүүлсэн ч биелэлт хангагдаагүй, тайлант онд өмнөх оноос авлага 1,533,337.9 мянган төгрөг, өр төлбөр 713,419.9 мянган төгрөг нийт 2,246,757.8 мянган төгрөгөөр тус тус өссөн байна, энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 170 мэдээллээс 57 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож, 106 мэдээллийг огт байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.2-т “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.4-т “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор”, 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр” заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Анхаарал татахуйц асуудал хот тохижуулах газраас орж ирж буй гудамж, замын гэрэлтүүлгийн үнэ 803.2 сая төгрөг, болон гэр хорооллын усны үнийн зөрүү 291.1 сая төгрөг нийт 1,094.4 сая төгрөгийн санхүүжилтийг авч үзэх

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Компанийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээний өөрийн хөрөнгийн дүн 8,368,670.5 мянган төгрөг байхад санхүүгийн тайланд өөрийн хөрөнгийн дүнг 5,231,568.7 мянган төгрөгөөр тусгаж 3,137,101.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

1.1. Эрсдэл: Компанийн өөрийн хөрөнгө буруу илэрхийлэгдэх

1.2. Өгсөн зөвлөмж: Компанийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээ болон санхүүгийн тайлангийн өөрийн хөрөнгийн дүнгүүд зөрүүтэй илэрхийлэгдсэн тул ТУЗ-аар хэлэлцүүлэн хууль, журамд нийцүүлэн шийдвэрлүүлэх.

##### 2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгаагүй ТУЗ-ийн гишүүдийн 2019 оны урамшуулал 4,078.8 мянган төгрөгийг 2020 онд нөхөн олгож, төлөвлөсөн зардлыг хэтрүүлсэн байна.

2.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

2.3. Өгсөн зөвлөмж: Компанийн дүрмийн 10.2 дах заалтыг хэрэгжүүлж, өр төлбөрийг санхүүгийн тайланд бүрэн тусгаж байх.

##### 3. Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн ерөнхий чиглэл

3.1 Илрүүлэлт: Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 02 сарын 13-ны өдрийн 2 дугаар тогтоолоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж мөрдөж ажиллаж байгаа ч татвар, нийгмийн даатгал болон бусад хууль тогтоомж, стандартын өөрчлөлтүүдийг тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.


3.2 Эрсдэл: Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

3.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт өөрийн байгууллагын онцлог үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж болон стандартын өөрчлөлтийг тусгаж хэрэгжүүлж ажиллах.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн .. тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР:  Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:  
АУДИТОР:  О.ГАНТУЯА

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>ЭРДЭНЭТ-УС ДТС ОНӨХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			ОРА-2021/3/СТА-ОНӨААН
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>ЭРДЭНЭТ-УС ДТС ОНӨХК</b>		Мян.төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	2019 оны санхүүгийн аудитаар авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зөвлөмж хүргүүлсэн ч биелэлт хангагдаагүй, тайлант онд өмнөх оноос авлага 1,533,337.9 мянган төгрөг, өр төлбөр 713,419.9 мянган төгрөг нийт 2,246,757.8 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.	2,246,757.8	Албан шаардлага	Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Д.Бүүвэйбаатар Д.Мөнхзул
2	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 170 мэдээллээс 52 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож, 106 мэдээллийг огт байршуулаагүй байна.		Албан шаардлага	Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Д.Бүүвэйбаатар Д.Мөнхзул
3	Компанийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээний өөрийн хөрөнгийн дүн 8,368,670.5 мянган төгрөг байхад санхүүгийн тайланд өөрийн хөрөнгийн дүнг 5,231,568.7 мянган төгрөгөөр тусгаж 3,137,101.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	3,137,101.7	Зөвлөмж	Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Д.Бүүвэйбаатар Д.Мөнхзул
4	Санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгаагүй ТУЗ-ийн гишүүдийн 2019 оны урамшуулал 4,078.8 мянган төгрөгийг 2020 онд нөхөн олгосон байна.	4,078.8	Зөвлөмж	Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Д.Бүүвэйбаатар Д.Мөнхзул
5	Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 02 сарын 13-ны өдрийн 2 дугаар тогтоолоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж мөрдөж ажиллаж байгаа ч татвар, нийгмийн даатгал болон бусад хууль тогтоомж, стандартын өөрчлөлтүүдийг тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.		Зөвлөмж	Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Д.Бүүвэйбаатар Д.Мөнхзул
<b>ДҮН</b>		<b>5,387,938.3</b>			

Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛИЙГ

ХЯНАСАН:  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР:  Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:  
АУДИТОР:  О.ГАНТУЯА





ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 78/22 ОН-2021/03 /СЭГ-ОИО/Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2019 оны санхүүгийн аудитаар авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зөвлөмж хүргүүлсэн ч биелэлт хангагдаагүй, тайлант онд өмнөх оноос авлага 1,533,337.9 мянган төгрөг, өр төлбөр 713,419.9 мянган төгрөг нийт 2,246,757.8 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зөвлөмжийн биелэлт хангагдаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Бүүвэйбаатар, ерөнхий нягтлан бодогч Д.Мөнхзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР: ..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР: ..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: ..... О.ГАНТУЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 73/23 ОДН-2021/03/СГА-ОНӨХК Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 170 мэдээллээс 57 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож, 106 мэдээллийг огт байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.2-т “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.4-т “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор”, 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр” гэж заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож,

давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуульд заасны дагуу сайтад мэдээллийг дутуу мэдээлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт-ус ДТС ОНӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Бүүвэйбаатар, ерөнхий нягтлан бодогч Д.Мөнхзул нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР:.....  Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР.....  Б.ЭРДЭНЭ

АУДИТОР.....  О.ГАНТУЯА